



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/200

Зуунмод

Дэмжлэг үзүүлж, зардал
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж орон нутгийн замд хяналтын телекамер нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлж, шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дэмжлэгт шаардагдах 3,760,000 (гурван сая, долоон зуун жаран мянга) төгрөгийг аймгийн нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэх данснаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т зөвшөөрсүгэй.

3.Орон нутгийн замд хяналтын телекамер нэвтрүүлэх ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (С.Магнайбаяр), Цагдаагийн газар (Б.Баянмөнх)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР




4124010499

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 28 -ны өдрийн 8/200 дүгээр
захирамжийн хавсралт



ОРОН НУТГИЙН ЗАМД ХЯНАЛТЫН ТЕЛЕКАМЕР
НЭВТРҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Хурд хэмжиж байна "Мэдээлэх самбар" байршуулах цэг			
1	Баян сумын Өгөөмөр 2 дугаар багийн төв зам дагуу (120 км)	1 ширхэг	940,000
2	Баянчандмань, Борнуурын чиглэлийн авто зам дагуу(54 км)	1 ширхэг	940,000
3	Сэргэлэн сумын Баянбүрд 1 дүгээр багийн Хангайн зөрлөгийн уулзварын зүүн талд (46 км)	1 ширхэг	940,000
4	Эрдэнэ сумын Баян даваагийн авто зам дагуу (70 км)	1 ширхэг	940,000
Нийт		4 ширхэг	3,760,000

ХЯНАСАН
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ

ТӨСӨВ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Л.ЦЭРЭННОРОВ